



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны  
Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2022/1/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Даланзадгад хот  
2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [tserenbayars@audit.gov.mn](mailto:tserenbayars@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [khongorzult@audit.gov.mn](mailto:khongorzult@audit.gov.mn)

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК

Захирал: Ш.Ичинхорлоо  
Утас: 77270808 Цахим хаяг: [nitsbalance@gmail.com](mailto:nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

|  | Үзүүлэлт  | 2020.12.31     | 2021.12.31     |
|--|---|----------------|----------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |   |                |                |
|  | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 16.3           | 20.4           |
|  | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 6,511.8        | 6355.5         |
|  | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>6,528.1</b> | <b>6,375.9</b> |
|  | Нийт өр төлбөрийн дүн                             |                |                |
|  | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 6,528.1        | 6,375.9        |
|  | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>6,528.1</b> | <b>6,375.9</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |   |                |                |
|  | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,497.1        | 915.4          |
|  | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,061.8        | 1,067.6        |
|  | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>435.3</b>   | <b>(152.2)</b> |
|  | Үйл ажиллагааны бус үр дүн                        | (0.5)          | 0              |
|  | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>434.8</b>   | <b>(152.2)</b> |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |   |                |                |
|  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 600.6          | 600.6          |
|  | Тайлант оны үр дүн                                | 5,927.5        | 5,775.3        |
|  | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>6,528.1</b> | <b>6,375.9</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |   |                |                |
|  | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 897.2          | 863.7          |
|  | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 897.2          | 863.7          |
|  | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>-</b>       | <b>-</b>       |
|  | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     |                | <b>0</b>       |
|  | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>-</b>       | <b>0</b>       |
|  | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>-</b>       | <b>-</b>       |
|  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                |                |
|  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |                |                |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |   |                |                |
|  | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>842.4</b>   | <b>794.1</b>   |
|  | Урсгал зардал                                     | 842.4          | 794.1          |
|  | Хөрөнгийн зардал                                  | -              | 0              |



|  |                                       |              |              |
|--|---------------------------------------|--------------|--------------|
|  | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b> | <b>841.4</b> | <b>793.1</b> |
|  | Улсын төсвөөс санхүүжих               | 608.8        | 572          |
|  | Орон нутгийн төсвөөс                  | 232.6        | 221.1        |
|  | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 1.0          | 1            |

### **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Өмнөговь аймгийн Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Сургуулийн зорилгын хэрэгжилтийг хангах, сургалтын тасралтгүй үйл ажиллагааг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уламжлалт ажлуудыг цар тахлын нөхцөл байдалд тохируулан зохион байгуулах,
  - Цаг үеийн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулах,
- Сургууль, эцэг эх, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааны тасралтгүй байдлыг дэмжих,

### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Дэлхийн банк ,БШУЯамнаас хамтарсан боловсролын чанарын шинэчлэлийн төслийн хүрээнд 4,299.0 мянган төгрөгний төсөл хэрэгжээд явж байна.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Баяндалай сумын ерөнхий боловсролын сургууль 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 311,915.7 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 7,749.7 мянган төгрөгийн 2 алдаа, 100,855.3 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 203,310.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба залруулагдаагүй



311,915.7 мянган төгрөгийн алдаа зөрчил, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 302,953.0 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр                        | Нийт алдаа, зөрчлийн |           | Үүнээс    |         |               |     |                 |           |         |           |
|-----|--|----------------------|-----------|-----------|---------|---------------|-----|-----------------|-----------|---------|-----------|
|     |  |                      |           | Залруулга |         | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |           | Зөвлөмж |           |
|     |  | Тоо                  | Дүн       | Тоо       | Дүн     | Тоо           | Дүн | Тоо             | Дүн       | Тоо     | Дүн       |
| 1   | Өмнөговь аймаг Баян-далай сум Ерөнхий боловсролын сургууль | 7                    | 311,915.1 | 2         | 7,749.7 | -             | -   | 2               | 100,855.3 | 3       | 203,310.1 |